



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/024

Эмээлтолгой

Ахуйн зориулалтаар загас
барихыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.12, 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байдрагийн гол, түүний цутгал голуудад тархан нутагшсан загасны төрөл зүйл ховордож байгаа тул ахуйн зориулалтаар загас барихыг 2 жилийн хугацаатай хориглосугай.

2. Амьтны нөөцийг хамгаалах, жам ёсоор өсөж, үржих боломжийг хангаж хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалан, олон нийтэд сурталчлан ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Ж.Сүхбаатар), байгаль хамгаалагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ



842301471